

Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдааны үеэр
Засаг даргын өгсөн үүрэг даалгавар

2022.11.15

№	Товч агуулга	Хяналт тавих байгууллага
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
	Сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх заавар зөвлөгөө, сэрэмжлүүлгийг тогтмол өгч, айл өрх бүрийн зуух яндангийн битүүмжлэл, аюулгүй байдлыг хангуулж, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх	ТНААХ
	Төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр биелүүлэхэд хяналт тавьж ажиллах	Татварын хэлтэс СТСХ
	Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй үзүүлж ажиллах	НХХ
	Байгууллагуудын ажилтан албан хаагчдын цагийн бүртгэл хангалтгүй байгаа тул цагийн бүртгэлийг ERP системээр бүртгэхэд анхаарч, хяналт тавьж ажиллах	ТЗУХ Холбогдох байгууллагууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын сургалтад албан хаагчдаа бүрэн хамруулах	ТЗУХ СТСХ
	Улс тунхагласны баярыг угтан дүүргийн ИТХ болон ЗДТГ-аас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд албан хаагчдаа сайтар хамруулах	ТЗУХ Төрийн байгууллагууд
	Агаарын бохирдлын суурин харуулын цэг байгуулах, утаа мэдрэгч байрлуулах талаар тооцоо судалгаа гаргаж Нийслэлийн агаарын бохирдлын газарт хүргүүлэх	ТНААХ
	Дүүргийн ИТХ-аар батлагдсан бараа материалын худалдан авалтыг чанартай хийж дуусгах	СТСХ
	70-86-р байрны дундах тохижилтын ажлын хүрээнд гэрэлтүүлгийг асаах ажлыг яаралтай зохион байгуулах	ТНААХ
	Багануур дүүргийн түүх, археологи, хүрээлэн буй орчны судалгаа хийлгэхтэй холбогдуулан эрдэмтэн, судлаачдын багтай хамтран ажиллах талаар судалж танилцуулах	НХХ
	Өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан отрын бүс дэх айл өрх, бэлчээрийн даац, өвс тэжээлийн судалгааг гаргаж танилцуулах	ХХҮХ
	Энэ сарын 18, 19-ний өдрүүдэд цас ихээр орж, цасан шуурга шуурах тул иргэд хөдөлмөрчдөд холын замд гарахдаа анхаарал болгоомжтой байх талаар сэрэмжлүүлэг хүргэх, холбогдох байгууллагууд бэлэн байдлыг хангаж ажиллах	ТЗУХ ТНААХ Цаг уурын өртөө
	Багануур ХК-тай хамтран 5 хорооны зорилтот бүлгийн болон дэмжлэг тусалцаа шаардлагатай иргэдэд хөнгөлөлттэй үнээр нүүрс нийлүүлэх ажлыг сайтар зохион байгуулах	ТНААХ
	2022 оны 11 сарын 15-ны өдрөөс 2023 оны 03 сарын 15-ны өдрийг хүртэл мотоциклийн хөдөлгөөнийг түр хориглож байгаа тул захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Цагдаагийн хэлтэс
	Их зохиолч Д.Нацагдоржийн 116 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулах яруу найргийн наадмыг өндөр түвшинд зохион байгуулах	НХХ

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

